



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582 Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.04.20 № 01/257

танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 4/1 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

019030106

G/Arkhib/Alban bichig 2024/ A5



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/12

Зуунмод сум

「Аудитын тайлан баталгаажуулах тухай」

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 7.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, санал дүгнэлт, зөвлөмжийг баталгаажуулсугай.

2. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар бичигдсэн 1,043.2 сая төгрөгийн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор Ц.Саранчимэг, Б.Адьяасүрэн, Г.Баянжаргал нарт үүрэг болгосугай.

4. Аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмж¹-ийн дагуу тодорхой арга хэмжээ төлөвлөж, илэрсэн алдаа зөрчлийг арилган, хэрэгжилтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид даалгасугай.

5. Аудитын тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг санхүүгийн аудитын аудиторуудад үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

¹ Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”

019810049

G/Arkhib/Alban bichig 2024/ tushaal

Дарга, Төргүүлэх аудиторын 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 416 тоот тушаалын хавсралт



Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар бичигдсэн албан шаардлагын жагсаалт

№	Аудитын нэр	Зөрчлийн товч утга	Албан шаардлага		Хариуцсан аудитор
			тоо	дүн	
1	Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Орон сууцны барилга угсралтын ажлын хамтран ажиллах гэрээний дагуу хүлээн авсан 203.7 сая төгрөгийн 3 орон сууц, Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулахтай холбоотойгоор худалдан авсан нийт 100.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 192.6 сая төгрөгийн бараа материал, нийт 498.3 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг орлогод авч, тайлагнаагүй байна.	1	498.3	Аудитор Т.Хүрэлбаатар
2	Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Төв аймгийн Засаг даргын "Бодьцогт" ХХК-тай 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан №0112021 дугаар бүхий "Төв аймгийн Зуунмод хотын 2 дахь ээлжийн орон сууцны барилгажилтын төслийн 1-р багц 1026 айлын орон сууцны барилгын хамтран ажиллах гэрээ"-ны дагуу 2023 онд хүлээлгэн өгсөн 61.95 м.кв 3 өрөө 1 орон сууцыг аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар тогтоолоор улсын цол авсан бөхөд бэлэглэсэн байна.	1	-	Аудитор Т.Хүрэлбаатар
3	Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Мал хамгаалах сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын байгууллагад 2024.03.15-ны өдөр ирүүлсэн, аудитад санхүүгийн тайлангийн тодруулга тайлбар хийж ирүүлээгүй, бараа материалын /нөөцийн өвс, тэжээл, тэжээлийн будаа/ тайлан, өвс тэжээлийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт ирүүлээгүй нь 346.4 сая төгрөгийн нөөцийн өвс, тэжээлийн үлдэгдлийг оршин буй эсэхийг нотлох боломжгүй байна.	1	346.4	Шинжээч Т.Майцэцэг
4	Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Аймаг хөгжүүлэх сангийн 2023 жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагын судалгаагаар өмнөх оны авлагын эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс 99,518.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь авлагын үлдэгдлийг оршин буй эсэхийг нотлох боломжгүй байна.	1	99.5	Аудитор Б.Адъяасүрэн
5	Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тогтмол мэдээлэх 157 мэдээллээс хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 39 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 86,0 хувьтай байна.	1	-	Аудитор Г.Баянжаргал
6	Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ой, Төв аймгийн баяр наадамд зориулан Төв сайхан нутаг хүндэтгэлийн тоглолт 2022 оны 12 дугаар сард зохион байгуулж аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 298.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 99.0 сая төгрөгийн билетийн орлого дутуу төвлөрсөн байна.	1	99.0	Аудитор Ц.Саранчимэг
ДҮН			6	1,043.2	

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/01/НА-СТА-ТЕЗ

ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: Khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: Amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 702723204 Цахим хаяг: Saranchimegts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	4
1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	5
1.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
1.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
1.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
1.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
1.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
2. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	10
3. АУДИТЫН ТАЙЛАН	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн.....	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	17
3.5.3 Авлага	17
3.5.4 Урьдчилгаа	18
3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	21
3.5.8 Өр төлбөр	21
3.5.9 Урт хугацаат өр төлбөр	22
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	24
3.6.3 Нэмэлт төсөв	24
3.8 Аудитын гол асуудал.....	29
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	29
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	29
3.9.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	30
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	31
3.10 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	31
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	31

4. Аудитын илрүүлэлт	32
4.2.3 Албан шаардлага хууль	32
4.2.4 Зөвлөмж.....	34
2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БНСБС	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	15
Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.....	15
Хүснэгт 3 Сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.....	16
Хүснэгт 4 Авлагын үлдэгдэл.....	17
Хүснэгт 5 Бараа материалын үлдэгдэл.....	19
Хүснэгт 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл.....	20
Хүснэгт 7 Богино хугацаат өр төлбөр.....	22
Хүснэгт 8 “Төв шууд”-ын харьяа байгууллагуудын өглөг.....	22
Хүснэгт 9 Нийт Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл	23
Хүснэгт 10 Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр.....	25
Хүснэгт 11 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт.....	26
Хүснэгт 12 Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.....	31

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

1.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		60,635,670.1	66,348,687.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	36,963,904.7	37,337,641.8
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	18,179,443.8	21,578,334.6
УРЬДЧИЛГАА	7а, 7б	32,358.5	59,798.5
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	5,446,169.1	7,358,863.5
НӨӨЦИЙН БАРАА	9а	13,793.9	14,048.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		107,748,350.3	135,801,585.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	107,748,350.3	135,801,585.2
Биет хөрөнгө		99,752,048.8	127,511,472.8
Биет бус хөрөнгө	13	7,990,711.5	8,284,522.5
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	5,590.0	5,590.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		168,384,020.4	202,150,272.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,803,500.3	6,436,768.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,953,539.4	5,474,358.6
Өглөг	17а, 17б	2,481,618.0	5,389,355.5
Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,471,921.3	85,003.1
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,849,961.0	962,410.1
Урт хугацаат зээл	20а, 20б	1,849,961.0	962,410.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		162,580,520.1	195,713,504.0
Засгийн газрын хувь оролцоо		162,580,520.1	195,713,504.0
Засгийн газрын оруулсан капитал		32,823,344.8	32,806,806.8
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		9,378,064.8	11,322,183.3
Хуримтлагдсан үр дүн		104,352,455.2	135,637,609.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		16,026,655.3	15,946,904.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		168,384,020.4	202,150,272.6

1.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		128,639,911.6	175,536,337.4
ТАТВАРЫН ОРЛОГО		40,427,702.7	56,538,510.5
Орлогын албан татвар		18,293,244.1	34,020,371.4
Хувь хүний орлогын албан татвар		18,321,779.2	26,076,528.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-626,802.8	-898,431.2
ААН-ын орлогын албан татвар		598,267.6	8,842,274.5
Хөрөнгийн албан татвар		11,148,852.7	12,007,621.4
Бусад татвар, төлбөр, хураамж		10,985,605.9	10,510,517.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	64,368,998.7	89,403,991.0
Нийтлэг татварын бус орлого		42,042,268.7	55,240,989.5
Хөрөнгийн орлого		715,756.4	333,803.4

Тусламжийн орлого		0.0	1,362,033.7
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		21,610,973.6	32,467,164.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		23,843,210.1	29,593,835.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	73,205,725.4	93,602,475.6
УРСГАЛ ЗАРДАЛ		67,406,991.2	82,349,923.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		65,485,100.2	80,473,885.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		14,243,921.3	21,536,882.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,836,968.9	2,761,636.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		17,795,936.2	10,831,512.6
Хангамж, бараа материалын зардал		1,902,085.2	2,277,990.4
Нормативт зардал		2,921,678.3	1,812,147.8
Эд хогшил, урсгал засварын зардал		965,714.1	376,892.5
Томилолт, зочны зардал		186,153.8	246,485.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,747,764.3	6,633,151.4
Бараа үйлчилгээний бусад зардал		21,884,878.1	33,997,186.5
ХҮҮ		321,830.7	883,050.9
ТАТААС		272,050.8	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,328,009.5	992,987.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		5,798,734.2	11,252,552.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		55,434,186.2	81,933,861.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	427.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		160,106,947.8	51,098,849.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-104,672,761.6	30,835,438.8

1.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	112,558,069.2	148,979,595.3
ТАТВАРЫН ОРЛОГО	41,806,450.3	55,147,067.6
Орлогын албан татвар	19,671,991.7	32,578,253.6
Хувь хүний орлогын албан татвар	18,232,466.2	26,076,528.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-626,802.8	-872,488.4
ААН-ын орлогын албан татвар	2,066,328.2	7,374,213.9
Хөрөнгийн албан татвар	11,148,852.7	12,007,621.4
Бусад татвар, төлбөр, хураамж	10,985,605.9	10,561,192.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,604,237.6	3,191,089.0
Газрын төлбөр	3,183,899.3	3,026,223.8
Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,197,469.0	4,343,879.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,097,404.7	66,925,865.0
Нийтлэг татварын бус орлого	24,770,674.7	30,792,127.2
Хөрөнгийн орлого	715,756.4	333,803.4
Тусламжийн орлого	0.0	3,332,770.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	21,610,973.6	32,467,164.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,654,214.3	26,906,662.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,009,870.9	72,286,922.7
УРСГАЛ ЗАРДАЛ	60,009,870.9	72,286,922.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,717,963.1	70,194,048.6

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,504,975.8	21,191,425.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,248,692.5	2,836,335.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,850,355.9	10,350,080.0
Хангамж, бараа материалын зардал	2,653,920.0	3,969,082.6
Нормативт зардал	1,771,927.5	1,793,814.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,022,311.0	405,083.6
Томилолт, зочны зардал	180,538.6	243,173.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,047,316.0	6,758,727.4
Бараа үйлчилгээний бусад зардал	14,437,925.9	22,646,326.9
ХҮҮ	321,830.7	883,050.9
ТАТААС	272,050.8	102,000.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,698,026.2	1,107,823.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	52,548,198.4	76,692,672.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	44,834,361.4	71,870,228.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,834,361.4	71,870,228.6
Дотоод эх үүсвэрээр	44,834,361.4	71,870,228.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-44,834,361.4	-71,870,228.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-3,146,689.6	-4,437,520.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,146,689.6	4,437,520.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,567,147.3	384,923.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	32,396,757.4	36,963,904.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,963,904.7	37,337,641.8

1.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	281,772,263.8	281,772,263.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-16,078,410.0	-16,078,410.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,693,853.8	265,693,853.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-168.8	-168.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-665,111.7	-665,111.7
Өмчид гарсан өөрчлөлт	2,224,708.3	2,224,708.3
Тайлант үеийн үр дүн	-104,672,761.6	-104,672,761.6
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,580,520.1	162,580,520.1
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	162,580,520.1	162,580,520.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	355,511.8	355,511.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,936,031.9	162,936,031.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-47,679.3	-47,679.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,989,712.5	1,989,712.5
Тайлант үеийн үр дүн	30,835,438.8	30,835,438.8
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	195,713,504.0	195,713,504.0

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	121,293,053.4	100,839,273.3
УРСГАЛ ЗАРДАЛ	54,135,854.9	50,256,553.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,424,424.1	48,689,189.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,101,576.8	16,725,005.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,141,226.6	2,064,520.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,010,626.1	17,011,586.8
Хангамж, бараа материалын зардал	1,262,477.8	1,234,296.2
Норматив зардал	173,868.1	169,925.0
Эд хогшил, урсгал засварын зардал	566,862.8	541,110.7
Томилолт, зочны зардал	266,774.2	242,371.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,044,768.4	1,944,921.6
Бараа үйлчилгээний бусад зардал	10,856,243.3	8,755,451.5
ХҮҮ	883,051.0	883,050.9
ТАТААС	102,000.0	102,000.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	102,000.0	102,000.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	726,379.8	582,313.3
Бусад урсгал шилжүүлэг	726,379.8	582,313.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	62,720,511.6	47,825,199.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,436,686.9	2,757,520.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	121,293,053.4	100,494,013.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,671,311.8	20,398,047.5
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,488,718.9	74,817,331.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	29,045,110.5	1,945,863.7
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	7,087,912.2	3,332,770.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,096,855.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,698,099.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,934	1,984
БАЙГУУЛЛАГЫН ТОО	62	62
Төсвийн байгууллага	62	62
АЖИЛЛАГСДЫН ТОО	936	961
Удирдах ажилтан	253	249
Гүйцэтгэх ажилтан	395	421
Үйлчлэх ажилтан	119	134
Гэрээт ажилтан	169	157
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	936	961
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	410	396
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	32
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	-	1
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	337	346
Гэрээт ажилтан	1	1
Улс төрийн албан хаагч (УТ)	184	181

1.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,622,605.8	8,144,184.4
УРСГАЛ ЗАРДАЛ	4,721,386.9	6,740,293.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,902,083.8	5,281,778.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,949.3	1,310,820.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,477.6	151,172.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,925.7	14,604.0
Хангамж, бараа материалын зардал	68,941.7	84,167.4
Эд хогшил, урсгал засварын зардал	440,516.8	95,054.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,995.2	227,390.1
Бараа үйлчилгээний бусад зардал	2,267,277.4	3,398,570.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,819,303.1	1,458,514.5
Бусад урсгал шилжүүлэг	697,156.3	412,685.0
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,122,146.8	1,045,829.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	901,218.9	1,403,891.0
Дотоод эх үүсвэрээр	901,218.9	1,403,891.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,564,261.6	8,144,184.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	5,564,261.6	8,144,184.4

2. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуушмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.04.20 № 01/260
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.МӨНХБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 18 дугаар хуралдааны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай" 04 дүгээр тогтоолоор 52 зорилт, 274 арга хэмжээний хэрэгжилтийг 95,29 хувийн гүйцэтгэлтэй буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна. Мөн "Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэх тухай" 02 дугаар тогтоолоор 50 зорилт, 265 арга хэмжээ 92,63 хувийн гүйцэтгэлтэй "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/342 дугаар захирамжаар "Түүхт ой-Бүтээн байгуулалтыг дэмжих" урианы жилийн төлөвлөгөөг 3 зорилт 62 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батлуулан 95,9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн харьяа 63 төсөвт байгууллага, 11 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 103 тусгай сан, 28 төрийн сангийн нэгж, 4 данс нийт 209 тайлан нэгтгэгдсэнээс Төрийн аудитын газар нь 63 төсөвт байгууллага, 102 тусгай зориулалттай сан, 11 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 27 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 203 санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Жаргалант сумын Эко-төв Жаргалант ОНӨААТҮГ, Алтанбулаг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Шалгагдагч байгууллагуудын зөрчлийн хэмжээ буураагүй, удирдлагын гаргасан эрх зүйн алдаатай шийдвэр, орон нутагт санхүүгийн мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай,

G/Архив/Албан бичиг 2024/ А4
019020510

тогтвор суурьшилгүй байгаа зэрэг нь санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байсан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны ээлжит бус 3 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоол, мөн 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар хуралдааны 02 дугаар тогтоол, Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баяр наадам зохион байгуулах салбар хороодыг томилох тухай аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/329 тоот захирамж, Баяр наадмын зардал батлах тухай аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 09 тоот А/392 тоот захирамжаар 5.8 тэрбум төгрөг зарцуулсан.
- Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Arkhir/Alban bichig 2024/ A4

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Аймгийн хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах, худалдан борлуулахаар шийдвэрлэгдсэн хөрөнгийг борлуулж төсөвт төвлөрүүлэх, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, эмийн эргэлтийн санг эрүүл мэндийн төвүүдээс тусгаарлан, үйл ажиллагааг оновчтой хэлбэрээр зохион байгуулах зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг Г.Баянжаргал, Д.Бямбасүрэн, Ж.Бямбацогт, Т.Хүрэлбаатар, Б.Адьяасүрэн, Б.Одбилэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/520 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 60.1.1-60.1.21-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 18 дугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай” 04 дугаар тогтоолоор 52 зорилт, 274 арга хэмжээний хэрэгжилтийг 95,29 хувийн гүйцэтгэлтэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна. Мөн “Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэх тухай” 02 дугаар тогтоолоор 50 зорилт, 265 арга хэмжээ 92,63 хувийн гүйцэтгэлтэй “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/342 дугаар захирамжаар “Түүхт ой-Бүтээн байгуулалтыг дэмжих” урианы жилийн төлөвлөгөөг 3 зорилт 62 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батлуулан 95,9 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/243 дугаар захирамжаар баталсан ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь төсвийн захирагч болон санхүүгийн ажилтнуудад дээрх баримтын бичгийн талаар таниулж мэдээлэл бүрэн өгч ажиллаагүйгээс шалтгаалан бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, 36 дугаар зүйлийн 36.6-д заасны дагуу төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэн төрийн сангийн үйл ажиллагаанд, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба төсвийн орлого, зарлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д “Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ”, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ыг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/64 дугаартай захирамжаар Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баянцагаан, Баянжаргалан, Борнуур, Жаргалант, Мөнгөнморьт зэрэг нийт 10 сумын төрийн сангийн нэгжид дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр батлуулсан байна. Шалгалтаар санхүүгийн албаны дарга нар мэргэжил арга зүйгээр хангаж, санхүүгийн ажилтнуудад шаардлага, хяналт тавьж ажилладаггүй, зарлагын гүйлгээний хяналтыг тогтмол хэрэгжүүлдэггүй, төрийн сангийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй, төсвийн шууд захирагч нар төсөв санхүүтэй холбоотой эрх зүйн мэдлэг хангалтгүй, эд хариуцагч нарын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй дутагдал нийтлэг байгаа талаар дүгнэлт гаргасан байна. Цаашид анхаарах асуудлаар сумдад 16 зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэд Санхүү хяналт, дотоод аудитын албыг 7 орон тоотойгоор байгуулж, тус албаны дүрмийг батлан хяналт, шалгалтыг хийж шалгагдагч байгууллага болон дотоод аудитын хороонд тайлагнадаг байна.

Санхүүгийн хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөөний дагуу дотоод аудитын чиглэлээр 86, санхүүгийн хяналт шалгалтаар 104 нийт 190 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хамрагдаж 287.4 сая төгрөгийн 180 төлбөрийн акт, 6,320.8 сая төгрөгийн 47 албан шаардлага нийт 6,608.2 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Зөрчлийн ангиллаар

нь задалбал данс бүртгэлд тусгаагүй, тушаал шийдвэргүй акталсан 23,6 хувь, үндсэн баримтгүй зарцуулсан 17,8 хувь, өр авлага үндэслэлгүй хаасан 9,6 хувь, бусад зөрчил 35,5 хувь эзэлж байна. Сумдын эмийн эргэлтийн сан, Хоршоо хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, шилэн дансны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, шалгалтын дүнг дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн байгууллагын удирдлагуудад зөвлөмж гарган хүргүүлж ажилласан байна. Шалгагдагч байгууллагуудын зөрчлийн хэмжээ буурахгүй байгаа гол шалтгаан нөхцөл нь орон нутагт мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, орон нутагт ажиллаж байгаа бусад ажилтнууд хавсран гүйцэтгэдэг, эсвэл суманд хэд хэдэн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг нэг нягтлан бодогч хийдэг, цалин хөлс багатай ажлын ачаалал ихтэй байдаг зэрэг нягтлан бодогч нар тогтвор суурьшилгүйгээс жилд хэд хэдэн удаа солигддог нь нөлөөлсөн байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг жилд 2 удаа тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу бүх сум байгууллагуудад хийж, зөвлөн тусалдаг байна.

Төв аймгийн Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөний нийт зарлага 79,453.7 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 1,191.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 893.8 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,766.3 сая төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн байна. Энэ нь улсын төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	36,963.9	37,337.6	373.7
Авлага	18,179.4	21,578.3	3,398.9
Урьдчилгаа	32.4	59.8	27.4
Бараа материал	5,446.2	7,358.9	1,912.7
Нөөцийн бараа	13.8	14.0	0.3
Үндсэн хөрөнгө	107,748.4	135,801.6	28,053.2
Нийт хөрөнгө	168,384.0	202,150.3	33,766.3
Өр төлбөр	5,803.5	6,436.8	633.3
Засгийн газрын хувь оролцоо	162,580.5	195,713.5	33,133.0
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	168,384.0	202,150.3	33,766.3

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 36,963.9 сая төгрөг, тайлант оны үйл ажиллагааны мөнгөн орлого 293,140.1 сая төгрөг төвлөрч, харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд 213,640.3 сая төгрөгийг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 74,688.6 сая төгрөгийг, эргэн төлөгдөх зээлд 4,437.5 сая төгрөгийг зарцуулж, оны эцсийн үлдэгдэл 37,337.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө тайлагнагдсан байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 36,963.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 37,337.6 сая төгрөг болж, 373.7 сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 373.7 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 871.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 97,6 хувь буюу 36,435.5 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 2,4 хувь буюу 901.4 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд, 0.7 сая төгрөг нь байгууллагуудын кассад байршиж байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	8.4	0.7	-7.7
Төрийн сангийн харилцах	36,251.9	36,435.5	183.5
Банканд байгаа бэлэн мөнгө	703.5	901.4	197.9
Дүн	36,963.9	37,337.6	373.7
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			
Орон нутгийн ерөнхий орлого	23,797.2	24,668.6	871.4
Сумын орлогын дүн	14,869.9	18,120.9	3,251.0
Аймгийн ерөнхий орлогын дүн	8,906.7	6,547.8	-2,358.9
Төсөвт байгууллага	804.1	477.9	-326.2
Төсөл/ сан	12,232.8	11,983.8	-248.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	129.8	207.2	77.5
Дүн	36,963.9	37,337.6	373.7

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн харилцах дансанд байршиж буй 36,435.5 сая төгрөгийн үлдэгдлээс аймаг, сумын ерөнхий орлогын дансны үлдэгдэл 24,668.6 сая төгрөг, тусгай зориулалттай сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11,294.3 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн үлдэгдэл 472.5 сая төгрөг тус тус эзэлж байна.

Арилжааны банканд байгаа 901.4 сая төгрөгийн үлдэгдлээс 522.4 сая төгрөг нь эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл, 166.4 сая төгрөг нь Аймаг хөгжүүлэх сангийн үлдэгдэл, 207.2 сая төгрөг нь ТӨҮГ болон ОНӨҮГ-ийн үлдэгдэл, 5.4 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Тайлант оны жилийн эцсийн кассын 0.7 сая төгрөгийн үлдэгдлийг Аймгийн ИТХ, Заамарын хөгжил ОНӨААТҮГ, Тариалан дэмжих сан, Сэргэлэн сумын эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 871.4 сая төгрөгөөр өссөн нь аймаг, сумын орлогын үлдэгдэл, орон нутгийн буцаан төвлөрүүлсэн мөнгөтэй холбоотой байна.

Тусгай зориулалттай сангуудын мөнгөн хөрөнгө

Тусгай зориулалттай сангуудын мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл Төрийн сангийн харилцах дансанд 11,294.3 сая төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 688.9 сая төгрөг, касс бэлэн мөнгө дансанд 0.6 сая төгрөг тус тус байршиж байна.

Хүснэгт №3. Сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Касс байгаа мөнгө	Банк дахь бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сан
Эмийн эргэлтийн сан	562.9	522.5	0.04	522.4	-
Орон нутгийн хөгжлийн сан	3,844.2	4,315.4	-	-	4,315.4
Сум хөгжүүлэх сан	2,209.2	1,354.7	-	-	1,354.7
Байгаль хамгаалах сан	377.1	407.9	-	-	407.9
Мал хамгаалах сан	83.8	79.7	-	-	79.7
Хөрөнгө оруулалт, хөгжлийн барьцаа сан	4,327.30	5,129.2	-	-	5,129.2
Тариалан дэмжих сан	0.6	0.6	0.6	-	-
Аймаг хөгжүүлэх сан	820.2	166.4	-	166.4	-
Хөрөнгө, оруулалт	7.4	7.4	-	-	7.4
Дүн	12,232.7	11,983.8	0.6	688.9	11,294.3

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 248.8 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сан 854.5 сая төгрөг, аймаг хөгжүүлэх сан 653.8 сая төгрөг, эмийн эргэлтийн сан 40.4 сая төгрөг, мал хамгаалах сан 4.1 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалт, хөрөнгийн барьцаа сан 801.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 471.2 сая төгрөг, байгаль хамгаалах сан 30.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Төрийн улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл цалин олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчид болон нэг албан хаагчид хоёр удаа давхардуулан үр дүнгийн урамшуулал олгосон зөрчилд 183.6 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдсэн.

- Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй гаргасан гүйлгээнд 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 45.9 сая төгрөгийн албан шаардлага, 18.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.
- Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд 17.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 113.7 сая төгрөгийн албан шаардлага, 0.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.
- Ажил гүйлгээг бүртгээгүй, үлдэгдэлтэй гарсан, үлдэгдлийг төвлөрүүлээгүй зөрчилд 15.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 68.5 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

3.5.3 Авлага

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлага дансны оны эхний үлдэгдэл 18,179.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 21,578.3 сая төгрөгөөр тайлагнаж өмнөх онтой харьцуулахад 3,398.9 сая төгрөгөөр буюу 18,7 хувиар өссөн байна.

Хүснэгт №4. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	187.3	79.0	-108.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	3.0	47.4	44.4
Зээлийн хүүгийн авлага	86.0	97.9	11.8
Дансны авлага /ТӨҮГ/	4.6	12.0	7.4
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	31.7	46.5	14.8
Бусад авлага	16,025.8	20,337.5	4,311.7
Зээлийн авлага	1,841.0	957.9	-883.1
Дүн	18,179.4	21,578.3	3,398.9
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	10,872.9	14,053.6	3,181.2
Төсөл/ сан	4,619.7	5,459.4	839.9
Төрийн сан	1,850.3	982.9	-867.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	836.5	1,082.4	245.2
Дүн	18,179.4	21,578.3	3,398.9

Эх сурвалж: Төв аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагын төрлөөр авч үзвэл төсөвт байгууллагын авлага өмнөх оноос 3,181.2 сая төгрөг буюу 29,3 хувиар, төсөл, сан 839.9 сая төгрөг буюу 18,2 хувиар ОНӨААТҮГ-ын авлага 245.2 сая төгрөг буюу 29,3 хувиар өссөн бөгөөд төрийн сангийн авлага 867.4 сая төгрөг буюу 46,9 хувиар буурсан байна.

Тайлант онд авлага дансны эцсийн үлдэгдэл 127 байгууллагатай холбоотой үүссэн 21,578.3 сая төгрөгийн авлагын бүтцийг харуулбал:

- 240.1 сая төгрөг буюу 1,1 хувийг Эмийн эргэлтийн сан
- 2,387.2 сая төгрөг буюу 11,1 хувийг Орон нутгийн хөгжлийн сан
- 8,802.3 сая төгрөг буюу 40,8 хувийг Хоршоо хөгжүүлэх сан
- 79.6 сая төгрөг буюу 0,4 хувийг Тариалан эрхлэлтийг дэмжих сан
- 5,377.0 сая төгрөг буюу 24,9 хувийг Аймаг хөгжүүлэх сан
- 190.2 сая төгрөг буюу 0.9 хувийг Мал хамгаалах сан
- 982,9 сая төгрөг буюу 4,6 хувийг төрийн сан ОНӨО
- 474.5 сая төгрөг буюу 2,2 хувийг Засаг даргын Ерөнхий данс

- 842.3 сая төгрөг буюу 3,9 хувийг ОНӨААТҮГ-ын авлага
- 2,202.2 сая төгрөг буюу 10,2 хувийг бусад төсөвт байгууллагуудын авлага тус тус эзэлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2,387.2 сая төгрөгийн авлага нь хөрөнгө оруулалтын ажил бүрэн хийгдэж хүлээн аваагүйгээс үүссэн 20 байгууллагын авлага байна.

ОНӨААТҮГ-ын 842.3 сая төгрөгийн авлага нь Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын 833.2 сая төгрөг, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 7.3 сая төгрөг, Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 1.2 сая төгрөг, Орон сууцны корпорацийн 0.5 сая төгрөг, Сэргэлэн нутгийн хөгжил ОНӨААТҮГ-ын 0.1 сая төгрөгөөс бүрдэж байна.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Авлага барагдуулаагүй, авлага их хэмжээгээр үүсгэсэн Баяндэлгэр, Баянжаргалан, Борнуур сумдын ЗДТГ, Аймгийн ЗДТГ, Эрдэнэ сумын эмийн эргэлтийн сан, Заамар хөгжил ОНӨААТҮГ, Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ зэрэг 7 байгууллагын 485.4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.
- Харилцагч байгууллагатай авлагын тооцоо үүсгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг барагдуулаагүй Дэлгэрхаан, Аргалант сумдын Засаг дарга, Баяндэлгэр, Алтанбулаг, Архуст, Сэргэлэн сумдын Хоршоо хөгжүүлэх сан, Угтаалцайдам, Батсүмбэр сумдын ЗДТГ, Барилга захиалагч, орон сууцны корпорац зэрэг 9 байгууллагын 666.2 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 6 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.
- Тайлант оны авлагыг зөрүүтэй тайлагнасан, зээлийн авлагын үлдэгдлийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд зөрүүтэй байршуулсан, хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулаагүй Баян, Цээл, Сэргэлэн сумдын ЗДТГ, Баяндэлгэр, Баянцагаан, Бүрэн, Сүмбэр, Эрдэнэсант, Баян-Өнжүүл, Мөнгөнморьт, Сэргэлэн сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 11 байгууллагад 1,352.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 9 зөвлөмж өгөгдсөн байна.

3.5.4 Урьдчилгаа

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 32.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 59.8 сая төгрөг болж, өмнөх оноос 27.5 сая төгрөгөөр буюу 85,1 хувиар өссөн байна. Энэ нь Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын халаалтын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж худалдан авахаар урьдчилгаа төлбөр шилжүүлсэн үлдэгдэл байна.

3.5.5 Бараа материал

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дах бараа материалын эцсийн үлдэгдэл 7,372.9 сая төгрөг болж, оны эхнээс 1,912.9 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын тодруулгаар тайлант онд 14,166.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 12,253.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал	5,446.2	7,358.8	1,912.6
Тусгай зориулалттай материал	419.9	650.0	230.1
Эм боох материал	914.7	983.9	69.2
Дуусаагүй үйлдвэрлэл	26.0	9.5	-16.5
Бэлэн бүтээгдэхүүн	53.5	28.8	-24.7
Бичиг хэргийн материал	65.6	110.2	44.6
Аж ахуйн материал	1,160.8	2,025.9	865.1
Сэлбэг хэрэгсэл	293.9	348.9	55.0
Түлш, шатах тослох материал	42.8	37.9	-4.9
Барилгын засварын материал	15.0	36.1	21.1
Хүнсний материал	13.5	15.0	1.5
Бусад хангамжийн материал	2,195.6	2,765.1	569.5
Биологийн хөрөнгө	7.7	7.7	0.0
Мал амьтад	237.2	339.4	102.2
Нөөцийн бараа	13.8	14.0	0.2
Тэжээлийн нөөц	9.0	0.0	-9.0
Бусад нөөц	4.8	14.0	9.2
Дүн	5,460.0	7,372.9	1,912.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр:</i>			
Төсөвт байгууллага	3,758.9	5,544.5	1,785.6
Төсөл/ сан	1,261.2	0.0	-1,261.2
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	439.9	1,828.3	1,388.4
Дүн	5,460.0	7,372.9	1,912.9

Эх сурвалж: Төв аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалыг байгууллагын бүтцээр нь авч үзвэл 5,544.5 сая төгрөг буюу 75,2 хувийг төсөвт байгууллага, 1,828.3 сая төгрөг буюу 24,8 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал эзэлж байна. Бараа материалын үлдэгдэл 1,912.9 сая төгрөгөөр өссөн нь Аймгийн Засаг даргын тамгын газрын бараа материалын данс 578.2 сая төгрөгөөр, Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын бараа материалын данс 212.2 сая төгрөгөөр, Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын бараа материалын данс 114.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Төв аймгийн Мөнгөнморьт, Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд хөрөнгийн зардлаас бараа материалын зардалд 200.3 сая төгрөг зарцуулсан зөрчилд зөвлөмж, албан шаардлага өгсөн.
- Төв аймгийн Баяндэлгэр, Жаргалант, Дэлгэрхаан, Угтаалцайдам сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 161.7 сая төгрөгийн бараа материалын эцсийн үлдэгдэл жилийн эцсийн тооллогын дүнгээс зөрүүтэй, бараа материалыг тоолоогүй, тооллогын баримт материалыг ирүүлээгүй 5 зөрчилд зөвлөмж өгсөн.
- Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төвийн бараа материалын үлдэгдлийг өмнөх оноос нэмэгдүүлж бараа материал нөөцөлсөн, Ковидын үед бэлтгэсэн ариутгагч, нэг удаагийн маск, бээлий, халаад, нүүрний хаалт зэрэг нь ашиглалтгүйгээр үлдэгдэлтэй байгаа 28.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 135,801.5 сая төгрөг болж, өмнөх оноос 28,053.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	57,973.0	76,722.3	18,749.3
Авто-тээврийн хэрэгсэл	5,865.0	6,416.4	551.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,413.2	10,217.8	2,804.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	992.2	1,419.7	427.5
Зам, гүүрний байгууламж	13,009.8	13,486.6	476.8
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	31.1	31.1	0.0
Бусад үндсэн хөрөнгө	12,661.8	17,360.7	4,698.9
Дуусаагүй барилга, байгууламж	1494.5	1,522.4	27.9
Ном	311.3	334.1	22.8
Программ хангамж	116.6	117.8	1.2
Бусад биет бус хөрөнгө	7,874.1	8,166.6	292.5
Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	5.6	5.6	0.0
Дүн	107,748.3	135,801.5	28,053.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	89,189.0	115,487.3	26,298.3
Төсөл/ сан	66.1	4.9	-61.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	18,493.2	20,309.3	1,816.1
Дүн	107,748.3	135,801.5	28,053.2

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 81,1 хувь буюу 110,165.0 сая төгрөгийг сумын ЗДТГ, 0,2 хувь буюу 321.4 сая төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бусад төсөвт байгууллага 3,6 хувь буюу 4,981.7 сая төгрөг, 0,14 хувь буюу 196.9 сая төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө, 0,02 хувь буюу аймаг хөгжүүлэх болон хоршоо хөгжүүлэх сан 24.0 сая төгрөг, 14,8 хувь буюу 20,112.4 сая төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчит газрууд эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 8,838.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 12,602.5 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 3,216.1 сая төгрөг, бусад 14,378.8 сая төгрөгөөр нийт 39,035.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан борлуулсан 44.6 сая төгрөг, акталж данснаас хассан 979.6 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 334.9 сая төгрөг, бусад 5.4 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 124.4 сая төгрөг, нийт 1,489.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй нийт 1,522.4 сая төгрөгийн хөрөнгө нь Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 58.0 сая төгрөгийн 24 айлын орон сууц, Баян сумын Засаг даргын Тамгын газрын 297.5 сая төгрөгийн авто зам, Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 43.0 сая төгрөгийн ногоон байгууламж, сургуулийн хүүхдийн хөдөлмөр зуслангийн барилга, Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын 1,123.8 сая төгрөгийн Дулааны станцын барилга байна.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Баяндэлгэр, Жаргалант, Алтанбулаг, Архуст, Сэргэлэн сумдын Засаг даргын Тамгын газарт элэгдлээрээ өртгөө нөхсөн 1,202.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дансны 8 зөрчилд зөвлөмж өгсөн.
- Баянцагаан, Баянжаргалан, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант сумдын Засаг даргын Тамгын газар, Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллого хийсэн боловч тооцоог бодоогүй, санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл жилийн эцсийн тооллогын дүнгээс зөрүүтэй 1,756.5 сая төгрөгийн 6 зөрчилд 1 албан шаардлага 5 зөвлөмж өгсөн.
- Төв аймгийн Алтанбулаг, Архуст, Дэлгэрхаан, Өндөрширээт, Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газарт үндсэн хөрөнгө орлогод аваагүй, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалд бүртгэсэн, газар эзэмших эрхийг дутуу бүртгэсэн 154.0 сая төгрөгийн 5 зөрчилд 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн.
- Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газарт Гадаадын иргэн, харьяатын газар-агаарын замын боомт хариуцсан газрын ажилчдын автобусыг 99.8 сая төгрөгөөр төсвийн хөрөнгөөр худалдан авсан зөрчилд албан шаардлага өгсөн.
- Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газарт Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн наадмын талбайн засвар үйлчилгээ, төрийн албан хаагчийн байрны засварын ажлуудыг дуусаагүй, хүлээн аваагүй байхад барилга байгууламж дансыг 164.3 сая төгрөгөөр капиталжуулан бүртгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

3.5.8 Өр төлбөр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөр дансны эхний үлдэгдэл 5,803.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,436.7 сая төгрөг болж, өмнөх оныхоос 633.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Жилийн эцсийн нийт өр төлбөрийн 85,0 хувь буюу 5,474.4 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөр, 15,0 хувь буюу 962.4 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 3,953.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,474.4 сая төгрөг болж, өмнөх оныхоос 1,520.9 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд өр төлбөр дансны үлдэгдэл 1,520.9 сая төгрөгөөр өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Төсөвт байгууллагуудын өглөг 1,229.1 сая төгрөгөөр нэмэгдсэн
- Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын өглөг оны эхэнд 1,311.7 сая төгрөг, оны эцэст 2,730.9 сая төгрөг болж 1,419.0 сая төгрөгөөр, Төв эрдэнэс ОНӨААТҮГ-ын өглөг оны эхэнд 85.5 сая төгрөг, оны эцэст 118.1 сая төгрөг болж 32.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн
- Мал хамгаалах сангийн өглөг оны эхэнд 31.3 сая төгрөг, оны эцэст 33.9 сая төгрөг болж 2.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №7 *Богино хугацаат өр төлбөр*

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
Ажилчидтай холбогдсон өглөг	61.4	150.0	88.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	161.1	520.7	359.6
Байгууллагад төлөх өглөг	1,816.6	3,908.5	2,091.9
Хувь хүмүүст төлөх өглөг	21.5	44.0	22.5
Татварын өглөг /ТӨҮГ/	357.6	290.7	(66.9)
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	54.0	472.3	418.3
Дансны өглөг /ТӨҮГ/	9.4	3.0	(6.4)
Урьдчилж орсон орлого	1,471.9	85.0	(1,386.9)
Дүн	3,953.5	5,474.4	1,520.8
Үүнээс: Байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	402.8	1,631.9	1,229.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,727.9	3,287.0	1,559.1
Төрийн сан	1,468.1	241.9	(1,226.1)
Төсөл/ сан	354.7	313.6	(41.1)
Дүн	3,953.5	5,474.4	1,520.8

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт богино хугацаат өр төлбөрийн 3,091.7 сая төгрөг буюу 56,5 хувийг “Төв шууд”-ын харьяа байгууллагуудын өглөг эзэлж байна. Үүнд:

Хүснэгт №8 *“Төв шууд”-ын харьяа байгууллагуудын өглөг*

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Эцсийн үлдэгдэл	Хувийн жин
1	Тө. Засаг даргын ерөнхий данс	0.9	0.03%
2	Тө. Засаг даргын тамгын газар	19.8	0.6%
3	Тө. Тариалан эрхлэлтийг дэмжих сан	67.3	2.2%
4	Тө. Мал хамгаалах сан	33.9	1.1%
5	Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ	2,730.9	88.3%
6	Тө. Санхүүгийн хяналт, аудитын алба	0.1	0.0%
7	Тө. Орон нутгийн өмчийн газар	118.1	3.8%
8	Төв Эрдэнэс	118.4	3.8%
9	Тө. Байгаль орчин, аялал жуулчлалын газар	2.2	0.1%
	Дүн	3,091.7	100%

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Харилцагч байгууллагатай өглөгийн тооцоо үүсгээгүй, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өглөгийг буруу дансаар бүртгэсэн Баян, Батсүмбэр сумдын Засаг дарга, Баянцагаан, Лүн, Сэргэлэн, Баянхангай, Угтаалцайдам, Эрдэнэ сумдын ЗДТГ, Батсүмбэр сум дундын ойн анги, Угтаалцайдам сумын БНСБСан, Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ 11 байгууллагын 410.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 7 зөвлөмж өгсөн байна.

3.5.9 Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөр дансны 2023 оны эхний үлдэгдэл 1,850.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 962.4 сая төгрөг болж 887.6 сая төгрөгөөр буурсан байна. Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээлийн үлдэгдэл 1,841.0 сая төгрөгөөс 958.0 сая төгрөг болж, 883.0 сая төгрөгөөр буурч, Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ-ын эрсдэлийн сангаас 4.5 сая төгрөгийн зарцуулалт гарч, 4.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд цэвэр хөрөнгө, өмч өөрчлөлтийн эхний үлдэгдэл 162,526.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 195,713.5 сая төгрөг болж, оны эхнээс 33,187.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9 Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	42,201.4	44,128.9	1,927.5
Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	16,026.7	15,946.9	-79.8
Хуримтлагдсан үр дүн	104,297.9	135,637.6	31,339.7
Өмчийн дүн	162,526.0	195,713.5	33,187.5

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн оны эхний үлдэгдлээс 33,187.5 сая төгрөг буюу 20,4 хувиар өссөн нь харьяа байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIII хуралдааны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолоор аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 7,175.4 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 35,009.2 сая төгрөгөөр, нийт 42,184.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь УИХ-аас аймгийн орон нутгийн төсвийн 2023 оны нийт орлогыг 35,079.9 сая төгрөг байхаар тооцоноос 7,104.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төв аймгийн ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын төсөв тодотгосон тогтоолд нийт 50,346.0 сая төгрөгөөр батлагдсан нь анхны баталсан төсвөөс 8,161.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд зарцуулах зарлагын нийт хэмжээг аймаг, сумдын ИТХ-ийн хуралдаанаар 100,072.1 сая төгрөгөөр баталсныг 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит бус VI хуралдааны 02 дугаар тогтоолоор тодотгон 121,177.9 сая төгрөгөөр буюу 21,105.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 16 хөтөлбөрт зориулан 121,177.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 54,020.7 сая төгрөгийг урсгал зардалд, 62,720.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх цэвэр зээлд 4,436.7 сая төгрөг зарцуулахаар батлагджээ.

Төсвийн ерөнхийлөн Захирагчийн 2023 онд зарцуулах нийт зардлын 20,671.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 64,373.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24,596.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 7,087.9 сая төгрөгийг хандив тусламжийн орлогоос, 4,448.7 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн зарлагыг өмнөх онтой харьцуулахад батлагдсан төлөвлөгөө 100,072.1 сая төгрөгөөс 3,437.7 сая төгрөгөөр, гүйцэтгэл 64,430.7 сая төгрөгөөс 36,406.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Сангийн

яамнаас Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагчийн 2023 онд зарцуулах тодотгосон төсвийн зарлагыг 121,177.9 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаас нийт 50,346.0 сая төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 54,749.9 сая төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 4,403.9 сая төгрөгөөр буюу 108,8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 12,069.1 сая төгрөг, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 20,671.3 сая төгрөг, нийт 32,740.4 сая төгрөг эх үүсвэр бүрдүүлэхээс, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 273.3 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-д заасны дагуу, 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага тодотгон батлагдсан төлөвлөгөөгөөр 121,177.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 100,839.3 сая төгрөгийг зарцуулж, 20,338.6 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэл 83,2 хувь байна. Энэ нь хөрөнгийн зардал 14,895.3 сая төгрөгөөр зарцуулагдаагүй, урсгал зардал 3,764.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсантай холбоотой байна.

Тусгай зориулалттай сангуудын батлагдсан төлөвлөгөөгөөр 4,464.7 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 1,940.9 сая төгрөг бүрдүүлж 2,523.8 сая төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Хандив тусламжийн орлого 7,087.9 сая төгрөгөөр төлөвлөж баталснаас 3,332.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 3,755.1 сая төгрөгөөр төвлөрүүлээгүй, туслах үйл ажиллагааны орлогыг 13.1 сая төгрөгөөр төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 453.3 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 885.7 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 28.2 сая төгрөгөөр, нормативд зардал 4.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 23.9 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 24.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 99.9 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний зардал 2,100.7 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 144.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 14,895.3 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 1,679.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Төсвийн зарцуулалтад бараа үйлчилгээний бусад зардал 2,102.4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 144.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 14,895.3 сая төгрөгөөр дутуу зарцуулж, зээлийн эргэн төлөлт эх үүсвэр дутуу бүрдсэнээс Хоршоо хөгжүүлэх сангийн зээл 1,679.2 сая төгрөгөөр төсвийн зарлагыг хэмнэхэд нөлөөлсөн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн тайланд нийт 8,144.2 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрчээ. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 359.8 сая төгрөг,
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6,315.5 сая төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,468.9 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

Энэ нь өмнөх оноос 2,584.0 сая төгрөгөөр буюу 46,5 хувиар нэмэгдсэн нь Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 6 хуралдааны тогтоолоор орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг олгосонтой холбоотой байна.

Хүснэгт №10 Нэмэлт дансны эх үүсвэр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	421.5	359.8	-61.7
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,857.4	6,315.5	3458.1
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,281.3	1,468.9	-812.4
Дүн	5,560.2	8,144.2	2,584.0

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 359.8 сая төгрөг байна. Хандив тусламжийн орлогыг задалбал:

- Аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойд зориулсан “Төв сайхан нутаг” хүндэтгэлийн тоглолтын тасалбарын орлого болон хандивын орлого 350.8 сая төгрөг,
- Цээл сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Цээл сумын ИТХ-ын тогтоолоор баталсан “Бэлчээр ашиглалт, отор нүүдлийг зохицуулах журам”-ын дагуу 11 отрын малчдаас бэлчээр ашигласны төлбөр нь 9.0 сая төгрөгийг тус тус тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор өвс тэжээлийн орлогыг тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант хугацаанд 8,144.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдсэнээс 7,098.4 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1,045.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг зардлын зүйлээр нь авч үзэхэд цалин, шимтгэлийн зардалд 1,462.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 14.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 84.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 95.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 227.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3,398.6 сая төгрөг, тэтгэмж

шагнал урамшууллын зардалд 412.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,403.9 сая төгрөг, нийт 7,098.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь өмнөх оны зардлын гүйцэтгэл 4,499.9 сая төгрөгөөс 2,598.5 сая төгрөгөөр буюу 57,7 хувиар зардал нэмэгдсэн байна.

Хүснэгт №11 Нэмэлт дансны зарцуулалт

/сая төгрөг/

Зардлын үзүүлэлт	Мөнгөн дүн
Цалин хөлс, Нийгмийн даатгалын шимтгэл	1,462.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14.6
Хангамж, бараа материалын зардал	84.2
Эд хогшил, урсгал засварын зардал	95.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	227.4
Бараа үйлчилгээний бусад зардал	3,398.6
Тэтгэмж, шагнал, урамшууллын зардал	412.7
Хөрөнгийн зардал	1,403.9
Зарлагын дүн	7,098.4

Эх сурвалж: Төв аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нэмэлт санхүүжилтийн данснаас орон нутгийн нэмэгдлийн зарцуулаагүй үлдээдлийг ТЭЗ-ийн дансанд төвлөрүүлээгүй зөрчилд 4.6 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдсэн.
- Нэмэлт санхүүжилтийн дансны эхний үлдээдлийг бууруулах бичилтээр зардал гаргаж баталгаажуулсан, хандивын орлогыг баримал барихад зарцуулсан болон гэрээ дүгнэлгүйгээр төсөл арга хэмжээний санхүүжилт олгосон зөрчилд 196.0 сая төгрөгийн албан шаардлага бичигдсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, харьяа төсвийн захирагч нарын 2023 оны худалдан авах ажиллагааны тайлангаар 1319 төсөл арга хэмжээнд 71,923.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрээ байгуулсан. Үүнээс Төсвийн ерөнхийлөн захирагч /өөрийн багц/-ийн худалдан авах ажиллагааны тайлангаар 18,485.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 103 төсөл арга хэмжээнд 14,811.1 сая төгрөгийн гэрээ байгуулж ажилласан байна.

Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын дагуу дотоодын үйлдвэрлэл эрхлэгч 687 иргэн, аж ахуй нэгжээс 15,919.3 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

Ерөнхий гэрээний дагуу 835.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл арга хэмжээнд 762.4 сая төгрөгийн гэрээ байгуулж цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх худалдан авалтын төлөвлөгөөг 31,898.3 сая төгрөгөөр батлан, 26,093.5 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоолоор аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Шилжих үлдэгдэл, Замын сан, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал гэсэн эх үүсвэрүүдээр хөрөнгө оруулалтын 195 төсөл, арга хэмжээнд 26,749.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 17,311.8 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 9,159.1 сая төгрөг, аймаг байгуулагдсаны 100 жилийн ой угтсан бүтээн байгуулалт болон хандив тусламжийн орлогыг 3,500.0 сая төгрөгөөр 146 хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэгч байгууллагад 9,682.0 сая төгрөг, захиалагчийн хяналтад 77.7 сая төгрөг, зураг төсөл зохиогчийн хяналтад 4,812.8 сая төгрөг тус тус олгосон байна.

Урьд оны шилжих үлдэгдлээс 16 арга хэмжээнд 8,906.7 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсан. Гүйцэтгэлээр 11 арга хэмжээнд 3,494.0 сая төгрөг зарцуулсан байна. Гүйцэтгэгч байгууллагад 2,910.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Замын сангийн хөрөнгөөр 2,170.0 сая төгрөг батлагдаж 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,186.8 сая төгрөг зарцуулсан. Гүйцэтгэгч байгууллагад 1,101.2 сая төгрөг, захиалагчийн хяналтад 12.0 сая төгрөг олгосон байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага буюу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 13 арга хэмжээг 700.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөснөөс Баянцогт сумын Гунын хөв цөөрмийн даланг сэргээн засварлах ажлын зураг төсөв хийлгэх, уул, уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээхгүй орхигдсон газруудад нөхөн сэргээх /Заамар, Сэргэлэн сумдад 10га талбайд/ , ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас учирсан хохирлын үнэлгээ хийлгэх, Байгаль орчны нэгдсэн хяналт, шалгалт зохион байгуулах зэрэг ажлуудаас бусад ажил хийгдэж 528.0 сая төгрөг зарцуулсан. Гүйцэтгэгч байгууллагад 528.0 сая төгрөг олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 2023 онд хэрэгжүүлэх 4 төсөл арга хэмжээнд 307.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 4 арга хэмжээнд 252.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтан жил бүр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж ажиллахад чиглэсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн Э-тайлангийн программыг ашиглан нэгтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн харьяа 63 төсөвт байгууллага, 11 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 103 тусгай сан, 28 төрийн сангийн нэгж, 4 данс нийт 209 тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс:

- Татан буугдсан Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгө, өр, авлагын үлдэгдэл нэгтгэгдсэн байна.
- Аймгийн хөрөнгийн Тө.Барьцаа, Тө.Орон нутгийн хөрөнгө оруулалт, Тө.Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт, Тө.Засаг даргын ерөнхий данс зэрэг данс нэгтгэгдсэн байна.
- Сангийн яамны Э-тайланд 19 сумын Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн санхүүгийн тайланг 17 сум Байгаль хамгаалах санд, Баян сум Мал хамгаалах санд, Баянчандмань сум орон нутгийн ерөнхий орлогын тайланд нэгтгэсэн өмнөх оны зөвлөмжөөр өгсөн зөрчлийг арилгаагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 63 төсөвт байгууллага, 102 тусгай зориулалттай сан, 11 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 27 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 203 санхүүгийн тайланд аудит хийгдлээ. Жаргалант сумын Эко-төв Жаргалант ОНӨААТҮГ, Алтанбулаг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Аудитад хамрагдсан 203 санхүүгийн тайлангаас 36 төсөвт байгууллага, 27 төсвийн төвлөрүүлэн захирагч 5 орон нутгийн өмчит байгууллагын нийт 68 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 27 төсөвт байгууллага болон 102 тусгай сангууд, 6 орон нутгийн өмчит байгууллага, нийт 135 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 27 санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт гаргаснаас 88,9 хувь буюу 24 санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй”, 7,4 хувь буюу Дэлгэрхаан, Баян-Өнжүүл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай”, Баяндэлгэр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд татгалзсан санал дүгнэлт өгөгдсөн.
- Төсвийн шууд захирагчийн 36 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас 69,4 хувь буюу 25 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 30,6 хувь буюу 11 байгууллагын (Аргалант, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянчандмань, Дэлгэрхаан, Жаргалант, Өндөрширээт, Сэргэлэн, Угтаалцайдам сумдын ЗДТГ-ын санхүүгийн тайланд) “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн.
- Орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас 60,0 хувь буюу 3 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 40,0 хувь буюу 2 байгууллагын Зуунмод цэцэрлэгжүүлэлт, Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, түүний харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 72,813.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 32,226.2 сая төгрөгийн алдааг залруулж, 562.3 сая төгрөгийн зөрчилд 93 төлбөрийн акт тогтоож, 14,729.0 сая төгрөгийн зөрчилд 79 албан шаардлага, 25,296.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 175 зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг төсөв захирагчаар ангилбал:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 15,619.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 12,228.5 сая төгрөгийн алдааг залруулж, 1,043.2 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 2,348.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдсөн.
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 20,894.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,127.0 сая төгрөгийн алдааг залруулж, 16.7 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 5,321.5 сая төгрөгийн зөрчилд 15 албан шаардлага, 11,429.6 сая төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж өгөгдсөн.
- Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 25,275.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 12,885.1 сая төгрөгийн алдааг залруулж, 545.6 сая төгрөгийн зөрчилд 88 төлбөрийн акт тогтоож, 7,520.1 сая төгрөгийн зөрчилд 51 албан шаардлага, 4,324.3 сая төгрөгийн зөрчилд 97 зөвлөмж өгөгдсөн.
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 678.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 53.2 сая төгрөгийн алдааг залруулж, 468.5 сая төгрөгийн 5 албан шаардлага, 156.6 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгөгдсөн.
- Тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 10,405.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,992.9 сая төгрөгийн алдааг залруулж, 375.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 7,037.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 24 зөвлөмж өгөгдлөө.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитыг аймгийн Засаг даргын харьяа төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайланд хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, тусгай зориулалттай сан бүрээр төлөвлөн хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтийг шалгагдагч байгууллагын удирдлагад хүргүүлэн ажиллалаа. Үүнд:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь 27 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС, ЭЭС, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангуудын санхүүгийн тайланд аудит хийгдсэн.
- Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Голден пэйж Аудит ХХК, Өлзийт экаунт аудит ХХК, Релаэнс секюритиз аудит ХХК нь Байгаль орчин аялал жуулчлалын газар, сум дундын Ойн ангиудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тогтмол мэдээлэх 157 мэдээллээс хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 39 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 86,0 хувьтай байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл нь:

- Аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- Хөрөнгийн зардал хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө концессын зүйлийн жагсаалт /12 дугаар сард/
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, өмч хөрөнгийн зарцуулалттай холбоотой 13 захирамж шийдвэрүүд мэдээлэгдээгүй байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь өмнөх санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 8 дугаар зүйлийн 8.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн

Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ”, 8.2-д “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, 8.4-д “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

- **Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-д “ аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- *Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 18,644.3 сая төгрөгийн 103 зөрчилд зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх 12 албан шаардлага, 91 зөвлөмж өгсөн байна.*

3.9.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны төсвийн жилд УИХ, Засгийн газраас гаргасан чиглэл удирдамжийн дагуу бүх шатны төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах, хурал зөвлөгөөн, сургалтуудыг цахимаар явуулах чиглэлийн дагуу дараах ажлууд хийгдсэн байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй Цахим үндэстэн буюу E-Mongolia системийг сумдад болон хөдөөгийн хүн ам ихээр суурьшсан зарим багийн төвүүдэд нэвтрүүлж, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 27 сумын интернэт мэдээллийн ажилтнууд болон 4 сумын 6 багуудад төрийн үйлчилгээг операторын хэлбэрээр үзүүлэх компьютер, принтер, модем бүхий иж бүрдэл тоног төхөөрөмж хүлээлгэн өгч иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Тайлант оны 5 дугаар сард аймагт Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын харьяа Төрийн цахим үйлчилгээний хэлтэс 5 хүнтэйгээр байгуулагдаж, “ХУР-ДАН” төвийг Үйлчилгээний нэгдсэн төвд, Шуудан холбооны газар болон аймгийн нэгдсэн эмнэлэгт “ХУР-ДАН” цэгийг байгуулан иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Хууль зүйн туслалцааны төв, Нотариат, Ж-мобайл, Скайтел, ДДиш, Хаан даатгал, Практикал даатгал, Төрийн банк, JA's зээлийн төв, УБЦТС ТӨХК Зуунмод төв зэрэг төр хувийн хэвшлийн нийт 16 байгууллага 670 гаруй төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээ, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр <https://erp.e-mongolia.mn> системийг нэвтрүүлэн, өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлж, өссөн дүнгээр 72 удаагийн цахим хурал, сургалтыг 27 сум, хэлтэс агентлагийн дунд зохион байгуулснаар цахим технологийг бүрэн нэвтрүүлж, төсөв зардлыг хэмнэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Төрийн сангийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг цахимжуулан Төрийн сангийн удирдлагын цахим системийг 27 сум, харьяа 34 байгууллагад бүрэн нэвтрүүлсэн байна. 2023 онд нийт 276.1 тэрбум төгрөгийн гүйлгээг 69036 удаа цахимаар хийж баталгаажуулсан байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн 0.6 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Аудитаар өгөгдсөн 1,833.3 мянган төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж хэвших зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитлагдсан эцсийн үлдэгдлийг тайлант хугацааны эхний үлдэгдлээр зөрүүгүй шилжүүлж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт №12 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.63	-	0	0
Албан шаардлага	1	1,833.30	1	1833.30	100
Зөвлөмж	2	2,984.50	1	2969.90	99.51
Нийт дүн	4	4,818.43	2	4803.20	49.88

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дараагийн аудитаар анхаарах асуудлаар 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, хандив, зарцуулалттай холбоотой асуудлыг Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 17,561.9 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс, аудитын явцад 12,228.5 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

1. Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 13.795.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д” дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд 8,964.8 сая төгрөгийг залруулсан тул нийт авлагын дансны үлдэгдлийн 4,830.1 сая төгрөгийн буюу 22,4 хувийн авлага тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулаагүй алдааг зөрчилд тооцож, зөвлөмж өглөө.

2. Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 3,766.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д” дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд 3,263.6 сая төгрөгийг залруулсан байна.

4.2.2 Төлбөрийн акт

4.2.3 Албан шаардлага хууль

Орон сууцны барилга угсралтын ажлын хамтран ажиллах гэрээний дагуу хүлээн авсан 203.7 сая төгрөгийн 3 орон сууц, Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулахтай холбоотойгоор худалдан авсан нийт 100.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 192.6 сая төгрөгийн бараа материал, нийт 498.3 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг орлогод авч, тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Төв аймгийн Засаг даргын "Бодьцогт" ХХК-тай 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан №0112021 дугаар бүхий "Төв аймгийн Зуунмод хотын 2 дахь ээлжийн орон сууцны барилгажилтын төслийн 1-р багц 1026 айлын орон сууцны барилгын хамтран ажиллах гэрээ"-ны дагуу 2023 онд хүлээлгэн өгсөн 61.95 м.кв 3 өрөө 1 орон сууцыг аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар тогтоолоор улсын цол авсан бөхөд бэлэглэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д заасан "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ой, Төв аймгийн баяр наадамд зориулан Төв сайхан нутаг хүндэтгэлийн тоглолт 2022 оны 12 дугаар сард зохион байгуулж аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд билетийн орлого 298.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 99.0 сая төгрөгийн билетийн орлого дутуу төвлөрсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг бүртгэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Мал хамгаалах сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын байгууллагад 2024.03.15-ны өдөр ирүүлсэн, аудитад санхүүгийн тайлангийн тодруулга тайлбар хийж ирүүлээгүй, бараа материалын /нөөцийн өвс, тэжээл, тэжээлийн будаа/ тайлан, өвс тэжээлийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт ирүүлээгүй нь 346.4 сая төгрөгийн нөөцийн өвс, тэжээлийн үлдэгдлийг оршин буй эсэхийг нотлох боломжгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Аймаг хөгжүүлэх сангийн 2023 жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагын судалгаагаар өмнөх оны авлагын эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс 99,518.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь авлагын үлдэгдлийг оршин буй эсэхийг нотлох боломжгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.2.4 Зөвлөмж

1. Арвилан хэмнэлт үр ашиг, үр нөлөөтэй холбоотой

Илрүүлэлт:

Аймаг хөгжүүлэх сангийн 2023 оны жилийн эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн 84 зээлдэгчийн 1,835,369.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл төлөгдөөгүй, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, шүүхэд шилжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлдэгчийн хамаарал бүхий этгээдийн мэдээллийг давхар оруулах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхэд шилжүүлэн нэхэмжилж авлагыг барагдуулах зөвлөмж өгөв.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009-2023 оны хоорондох 14 удаагийн тогтоолуудаар худалдан борлуулахаар шийдвэрлэгдсэн ч худалдан борлуулагдаагүй байгаа 512.8 сая төгрөгийн 80 ширхэг эд хөрөнгө байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шийдвэр гарсан хөрөнгүүдийг худалдан борлуулах ажлыг эрчимжүүлж, худалдан борлуулсан орлогыг орон нутгийн төсвийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлэх.

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

Илрүүлэлт:

Нийт авлагын дансны үлдэгдлийн 22,4 хувь нь тооцоо нийлсэн баримтаар баталгаажаагүйгээр авлагын тодруулга тайланд тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлагын тооцоог тооцоо нийлсэн баримтаар бүрэн баталгаажуулж байх, Э-тайлангийн авлагын тодруулга тайланд үлдэгдлийг зөв ангилж бүртгэсэн байдалд хяналт тавьж ажиллах

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Сумдын Эмийн эргэлтийн сангууд нь Эрүүл мэндийн төвүүдийн тамга, тэмдгийг ашиглан ЭМТ-ийн чиг үүрэгт байхгүй, зөвшөөрөлгүй үйлчилгээ явуулж, хувь хүн, иргэдэд борлуулалт хийсэн цахим баримтыг байгууллагын регистрээр шивж, татвар, байрны түрээс, ашиглалтын зардал төлөхгүй байна. Энэ нь Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3-д "хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх", 2.5-д "зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх", Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аймгийн хэмжээнд Эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн үнэлж, эрүүл мэндийн төвүүдээс тусгаарлан, үйл ажиллагааг хууль, журам, стандартад нийцүүлэн хувьчлах зэрэг оновчтой хэлбэрээр зохион байгуулах.

2. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	2	12,228.4			2	12,228.4	2	12,228.4		
ТТЗ	16	4,127.0	4	1,128.6	12	2,998.4	16	4,127.0		
ТШЗ	94	12,824.7	32	6,903.1	62	5,921.5	94	12,824.7		
ОНӨГ	4	53.1.2	2	2.5	2	50.6	4	53.1.2		
ОНТС	18	2,992.9	11	1,822.1	7	1,170.8	18	2,992.9		
Дүн	132	32,226.2	49	9,856.3	85	22,369.9	132	32,226.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	8	3,391.4			5	1,043.2	3	2,348.2		
ТТЗ	52	11,230.5	5	16.7	11	358.1	34	10,855.7	2	0.0
ТШЗ	212	8,946.4	88	545.6	43	4,332.5	80	4,068.3	1	0.0
ОНӨГ	12	625.2			5	468.6	7	156.6		
ОНТС	12	1,450.2			2	375.5	10	1,074.7		
Дүн	296	25,643.7	93	562.3	66	6,577.9	134	18,503.5	3	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ТЕЗ	2	0.0			1	0.0	1	0.0		
ТТЗ	12	5,537.3			4	4,963.4	8	573.9		
ТШЗ	24	3,443.5			8	3,187.6	16	255.8		
ОНӨГ	2	0.0					2	0.0		
ОНТС	14	5,962.8					14	5,962.8		
Дүн	54	14,943.6			13	8,151.1	41	6,792.6		
Нийт дүн	54	14,943.6			13	8,151.1	41	6,792.6		



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273623, И-мэйл: tuv_zdtg@tov.gov.mn

2024. 04. 19 № 05/729

танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлттэй танилцлаа.

Аудитаар өгөгдөх дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ю.БЯМБАЦОГТ

4124020686

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2-р байр
Утас: +976 70272582, +976 70273465

И-мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn